



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 02 сарын 04 өдөр

Дугаар A/06

Улаанбаатар хот

### “Улаанбаатарын өвлийн наадам 2019” арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 3/08 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.4.5, 1.4.6, 1.4.9, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 19/16 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн Эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1-58, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 20/17 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/67 тоот захирамж, газрын дүрмийн 2.5.3, 3.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчны улирлын хугацааг уртасгах зорилгоор “Улаанбаатарын өвлийн наадам 2019” арга хэмжээг 2019 оны 02 дугаар сарын 16,17-ны өдөр Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт байрлах “Скайресорт” цанын баазад зохион байгуулахыг Бодлого, төлөвлөлтийн хэлтэс /В.Батчимэг/-т үүрэг болгосугай.

2. “Улаанбаатарын өвлийн наадам 2019” арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар, шаардагдах төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. “Улаанбаатарын өвлийн наадам 2019” арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах төсөв болох 58 529 133 /тавин найман сая таван зуун хорин есөн мянга нэг зуун гучин гурван/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /Б.Батцож/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА *D. Batm* Д.БАТСҮХ



1150500076

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2019 оны 02  
сарын 04 өдрийн А/06 дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт

5284025 СБТ 48936 1118263502

### Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:

Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга  
В.Батчимэг

Гишүүд:

Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн  
хөгжлийн бодлого хариуцсан  
мэргэжилтэн Н.Алтанзаяа

Мэдээлэл, сурталчилгааны хэлтсийн  
хамтын ажиллагаа хариуцсан  
мэргэжилтэн З.Оюуншүр

Мэдээлэл, сурталчилгааны хэлтсийн  
олон нийтийн харилцаа хариуцсан  
мэргэжилтэн Г.Азжаргал

Нарийн бичгийн дарга:

Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн  
соёлын аялал жуулчлал, эвент  
хариуцсан мэргэжилтэн Б.Үржинханд

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2019 оны 02 сарын 04 өдрийн А/06 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

5284025 СБТ 8936 1118203502

“Улаанбаатар өвлийн наадам-2019” арга хэмжээний бэлтгэл ажлын төлөвлөгөө

№	Хийгдэх ажлууд	Хугацаа	Хариуцах мэргэжилтэн
<b>Наадмын бэлтгэл ажлын хүрээнд /ерөнхий/</b>			
1	Наадам зохион байгуулах тухай захирамж, удирдамж батлуулах, ажлын хэсгийг байгуулах, төсвийн төсөл боловсруулах	01.20-02.01	В.Батчимэг Б.Үржинханд
2	Хамтран зохион байгуулах байгууллагуудтай холбогдох, гэрээ байгуулах, дүгнэх, ажлын хэсгийн хурал зохион байгуулах	01.20-02.15	Б.Үржинханд Ш.Ундармаа
3	Мэдээлэл сурталчилгааны чиглэлээр хэвлэл, шторк, гадаадаас ирэх зочидтой холбоотой ажлын гэрээг байгуулах		МСХ Д.Жавхлан Б.Ишдорж Г.Азжаргал З.Оюуншүр
4	Талбайн хуваарилалт, зураг гаргах	01.8-01.20	Б.Үржинханд Б.Ишдорж “Скайрезорт” ХХК
5	Арга хэмжээний үеийн урлагийн тоглолт, хөтөлбөр гаргах, хөтөлгч бэлтгэх	01.15- 02.15,16,17	В.Батчимэг Н.Алтанзаяа
6	Арга хэмжээний төсвийг хурдан шуурхай шилжүүлэх, санхүүгийн баримт бүрдүүлэлтийг хийх	Тухай бүр	Б.Батцоож Д.Уянга
7	Арга хэмжээний үеэр ажиллах хүмүүсийн утасны жагсаалт гарган зохион байгуулагчдад өгөх	02.15	Н.Алтанзаяа Б.Үржинханд
8	Засаг даргын 2019 оны А/67 тоот захирамжийн хавсралтаар батлагдсан ажлын хэсгийн хуралдааныг ЗДТГ-т зохион байгуулах	02.12	Н.Алтанзаяа Б.Үржинханд
<b>Зочид, иргэд, байгууллагуудыг татан оролцуулах чиглэлээр</b>			
8	Зочдын нэрс гаргах	02.08-02.15	В.Батчимэг Д.Жавхлан
9	Ивээн тэтгэгч олох, хамтран ажиллах	01.08-02.13	Д.Жавхлан Б.Ишдорж Б.Үржинханд МСХэлтэс
10	Гаднаас жуулчид татах, гадаад оролцогчдын тоог нэгтгэх, хөтөлбөр гарган батлуулах, хөтөлбөрийн дагуу гадаад оролцогчдыг хариуцан ажиллах	01.08- 02.15,16,17	Д.Жавхлан З.Оюуншүр Г.Азжаргал
<b>Хэвлэл, зар сурталчилгааны чиглэлээр</b>			
11	Хэвлэлийн эх, анонс, урилга, мандат /зохион байгуулагч, оролцогч байгууллагуудын/ гэх мэт сурталчилгааны материалууд бэлтгэх	01.08-02.01	Д.Жавхлан Б.Ишдорж
12	Наадмын талаарх цуврал хэвлэлийн мэдээ, шторк бэлтгэх, интернэт болон олон нийтийн	01.08-02.15	Д.Жавхлан Г.Азжаргал

	хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээллэх, сошиал сувгийг идэвхжүүлэх		
13	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр шууд дамжуулах ажлыг хариуцах	02.16-17	Д.Жавхлан Б.Ишдорж
14	Монголын Оюутны холбоотой хамтарч оюутан залуучуудыг оролцуулах	02.16-17	Ц.Энхтүвшин Д.Болорчимэг
15	Зочид буудлуудад байрлаж буй гадаадын жуулчдад өвлийн наадмын талаар мэдээллийг хүргэж ажиллах	02.02-02.15	Х.Содномдэмбэрэл Ч.Энх-Отгон
16	Элчин сайдын яамдуудад албан бичиг хүргүүлэх, аялал жуулчлалын компаниудад мэдээлэл хүргэх	01.05-02.01	Д.Жавхлан МСХэлтэс
17	Нийтийн тээврийн асуудлаар уулзалт хийж шийдэл гаргах "Сити тур автобус"	01.10 - 02.15-17	В.Батчимэг Б.Ишдорж
18	Наадмын үеэр НАЖГ-ын гэрт байрлах эд зүйлс, хоол хүнс бэлтгэх	02.04-02.17	С.Баяржаргал Т.Туул
<b>Наадмын талбайг тохижуулах ажлын хүрээнд</b>			
19	Мөсөн шагайн, сурын талбай бэлтгэх	01.10 - 02.15	Б.Үржинханд Ш.Ундармаа -Мөсөн сурын холбоо -Мөсөн шагайн холбоо -Скай ресорт ХХК
20	Нохой чарганы талбай бэлтгэх	02.11-02.17	Б.Жаргалан
21	Мөсөн хана босгох, үйлчилгээний павилон ажиллуулах талбайг хариуцах,	02.11-02.17	Н.Алтанзаяа
22	Гэр байрлуулах	02.15-02.17	Б.Ишдорж Х.Содномдэмбэрэл
23	Узель, хөгжим, тайз бэлтгэх, чимэглэх	02.10 - 02.15	В.Батчимэг Б.Үржинханд
24	Наадмын үеэр ашиглах Улаанбаатар үсэг, туг чиглүүлэгч бэлтгэж, тээвэрлүүлэх	02.15	Б.Үржинханд Э.Даваамөнх Б.Ишдорж
25	Наадмын хөтөлбөрийг хэвлүүлж, самбаруудад байрлуулах	02.10-02.15	МСХэлтэс Б.Ишдорж
26	Арга хэмжээний үеэр ашиглах техник, тоног төхөөрөмж /станц, чанга яригч, уртасгагч, хөгжим аппаратур гэх мэт/ бэлтгэх	02.15	Б.Үржинханд МСХэлтэс
27	Бие засах газрын ажиллагаа, орчны цэвэрлэгээг хариуцуулах	02.16-17	"Скай ресорт" ХХК
<b>Наадам болох 2019.02.16-17-ны өдрүүдэд хариуцаж ажиллах хэсгүүд</b>			
№	Хариуцах тэмцээн, талбай, үйл ажиллагаа	Хариуцах эзэн	Хийх ажил
1	Тайз, дэлгэц, нээлтийн арга хэмжээ	В.Батчимэг Б.Үржинханд	Баталгаажуулах зураг авах, наадмын нээлтийн хөтөлбөрийн дагуу үйл ажиллагааг явуулах
2	Лед дээр шууд дамжуулалт хийх	Б.Үржинханд Г.Азжаргал	Баталгаажуулах зураг авах, тэмцээний үйл ажиллагааг хянах
3	Мөсөн хананы тэмцээн, хоол үйлчилгээний	Н.Алтанзаяа	Баталгаажуулах зураг авах, тэмцээний үйл ажиллагаа хянах

	байгууллагад хяналт тавих		
4	Мөсөн шагайн УАШТ	Б.Ишдорж	Баталгаажуулах зураг авах, тэмцээний үйл ажиллагааг хянах
5	Мөсөн сурын УАШТ	Ш.Ундармаа	Баталгаажуулах зураг авах, тэмцээний үйл ажиллагааг хянах
6	Регбигийн хотын аварга шалгаруулах тэмцээн	Д.Ганболд	Баталгаажуулах зураг авах, тэмцээний үйл ажиллагааг хянах
7	Параглайдингийн хотын аварга шалгаруулах тэмцээн	Б.Үржинханд	Баталгаажуулах зураг авах, тэмцээний үйл ажиллагааг хянах
8	Олс таталтын тэмцээн, буухиа тэмцээн, нохой чарга	Б.Жаргалан	Баталгаажуулах зураг авах, тэмцээний үйл ажиллагааг хянах
9	Уулын цанын Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээн	н.Уран-Өлзий	Баталгаажуулах зураг авах, тэмцээний үйл ажиллагааг хянах
10	Снөүбордын УАШТ	н.Уран-Өлзий	Баталгаажуулах зураг авах, тэмцээний үйл ажиллагааг хянах
11	Шууд дамжуулалт iKon	Г.Азжаргал	Баталгаажуулах зураг авах, тэмцээний үйл ажиллагааг хянах
12	Гадаад зочид төлөөлөгчид хариуцах	Д.Жавхлан З.Оюуншүр	Баталгаажуулах зураг авах, зочдын наадмын хөтөлбөрт оролцуулах
13	4 дугуйт мотоцикл болон шувуулахуйн үзүүлбэрт хяналт тавих	Б.Ишдорж	Баталгаажуулах зураг авах, үзүүлбэрийн үйл ажиллагааг хянах
14	Наадмын үеэр зохион байгуулагчдын хоол хүнс	С.Баяржаргал Ч.Энх-Отгон	Зохион байгуулагчдын хоолыг цайны цагийн үеэр өгөх
15	НАЖГ-ын гэр хариуцах	Д.Болорчимэг Б.Алтанчимэг	Наадмын үеэр гэрт орж ирсэн зочдыг угтах, хүлээж авах, мэдээлэл өгөх
16	Дотоод гадаадын жуулчдын аюулгүй байдлыг хангаж ажиллах	Х.Содномдэмбэрэл Э.Мөнхзул	Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн албаны Замын хөдөлгөөний хяналтын хэлтэстэй хамтарч ажиллах
17	Наадмын үеэр зохион байгуулалтын үеийн үйл ажиллагаанд оролцох	Э.Даваамөнх Б.Энхжин	Хэрэгтэй шаардлагатай үед гарсан ажлыг хийж гүйцэтгэхэд бэлэн байх
18	Санхүүтэй холбоотой ажил хариуцах	Д.Уянга	Шагнал, урамшуулалтай холбоотой мөнгө санхүү тооцоог хийх
19	Судалгааны маягыг иргэд жуулчдаас бөглүүлж авах	Бүх албан хаагчид	Судалгааны асуултыг бодитоор бөглүүлж авах

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2019 оны 02  
сарын 04 өдрийн А/06 дугаар  
тушаалын гуравдугаар хавсралт

5284025 СБТ 8936 1118263502

“Улаанбаатарын өвлийн наадам 2019” арга хэмжээг  
зохион байгуулах зардлын төсөв

№	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
<b>Талбайн тохижилтын зардал</b>				
1	Мөсөн шагайн талбай бэлтгэх	30:100м	6 402 400	6 402 400
2	Мөсөн сурын талбай бэлтгэх	20:7м*2	1 116 000	1 116 000
3	Мөсөн хананы талбай бэлтгэх	Багц	2 800 000	2 800 000
4	Арга хэмжээний тайз засал, хөгжим техникийн түрээс	Багц	9 800 000	9 800 000
5	Арга хэмжээний цахилгааны зардал	Багц	1 000 000	1 000 000
<b>Дүн</b>				<b>21 118 400</b>
<b>Зохион байгуулалтын арга хэмжээ</b>				
6	Рэгби ХАШТ-ний зохион байгуулалтын шагналын зардал	Багц	1 500 000	1 500 000
7	Мөсөн сурын УАШТ-ний шагналын зардал	Багц	1 025 000	1 025 000
8	Мөсөн сурын сонирхогчдын тэмцээний зохион байгуулалтын зардал, шагнал, шүүгчийн хөлс	Багц	320 000	320 000
9	Мөсөн шагайн УАШТ-ний шүүгчийн зардал	12 шүүгч /2 өдөр/	50 000	1 200 000
10	Мөсөн шагайн сонирхогчдын тэмцээний зардал, шагнал, шүүгчийн хөлс	Багц	320 000	320 000
11	Снөүбордын тэмцээний зохион байгуулалтын зардал	Багц	1 500 000	1 500 000
12	Цанын тэмцээний зохион байгуулалтын зардал	Багц	1 500 000	1 500 000
13	Мөсөн хананд авиралтын тэмцээний зардал, шагнал, шүүгчийн хөлс	Багц	320 000	320 000
14	Параглайдингийн ХАШТ-ний шагнал, үзүүлбэрийн зардал	Эрэгтэй, эмэгтэй 1-р байр	3 000 000	3 000 000
15	Гэр бүлийн буухиа тэмцээнийн шагнал, өргөмжлөл	Багц	240 000	240 000
16	Олс таталтын тэмцээний шагнал, өргөмжлөл	Багц	240 000	240 000
17	Сээр цохих тэмцээний зохион байгуулалтын зардал	Багц	240 000	240 000
18	Нохой чарганы тээвэрлэлтийн хөлс	4 удаа	150 000	600 000
19	Шувуулахуйн биет бус уламжлалт өв соёл болон	Багц	500 000	500 000

	махчин шувуудын танин мэдэхүйн хөтөлбөр			
20	Дөрвөн дугуйт мотоциклийн үзүүлбэр, парад	Багц	1 000 000	1 000 000
21	Хөтлөгчийн зардал	1 хүн /2 өдөр/	400 000	800 000
22	Сити тур автобусны гадаад, дотоодын иргэдэд үйлчлэх зардал	2 жолооч /3 өдөр/	70 000	420 000
23	Гэр түрээслэх	3 ш /2 өдөр/	200 000	1 200 000
24	Ачааны машин түрээслэх	Багц	300 000	300 000
25	Зохион байгуулагчдын хоол, цайны зардал	45 хүн /2 өдөр/	10 000	900 000
26	Цагдаагийн хашлага үйлчилгээ, тээвэрлэлт	Багц	300 000	300 000
<b>Дүн</b>				<b>17 425 000</b>
Сурталчилгаа, маркетингийн зардал				
27	Сурталчилгааны шторк бэлтгэх	Багц /20 сек/	1 500 000	1 500 000
28	Сүхбаатарын талбайд сурталчилгааны анонс хэвлүүлэх, тогтоох байрлуулах зардал	6:11м, 5 өдөр	2 207 000	2 207 000
29	ХУД-ийн 120 мянгатын автобусны буудлын самбарт анонс хэвлүүлэх, тогтоох, байршуулах	21,9:2.7м, 5 өдөр	1 300 000	1 300 000
30	Нийслэл дэлгэцээр шторк цацах	5 өдөр	150 000	750 000
31	Сошиал сувгаар өвлийн наадмын шууд дамжуулалт хийх	Багц	1 500 000	1 500 000
32	Скай-резорт дээр байрлуулах сурталчилгаа, хөтөлбөрийн анонс	34.65м <sup>2</sup> *7500	259 875	325 500
		8,75м <sup>2</sup> *7500 /1 ш/	65 625	
33	Зөөврийн анонс	2*1*2 хэмжээ 20 ширхэг	7 500	600 000
34	Туг /даавуун хэвлэл/	1:2м, 20ш	50 000	1 000 000
35	Далбаа /хангарьд/, тууз	Багц	33,233	33,233
36	Гадаад оролцогчдын зочид буудлын зардал	22 өрөө*3 хоног	105 000	6 930 000
37	Хоолны зардал	32 хүн*буддаа	20 000	3 840 000
<b>Дүн</b>				<b>19 985 733</b>
<b>Нийт дүн</b>				<b>58 529 133</b>